ЯРИЛЦЛАГА, НИЙТЛЭЛ · 2024 оны 3-р сарын 12

Ц.АЛДАРХИШИГ: ДОРНОГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРААС ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАЖ БАЙНА





Дорноговь аймгийн прокурорын газрын ерөнхий прокурор Ц.Алдархишигтэй тус аймгийн хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлийн гаралт шийдвэрлэлтийн талаар ярилцлаа.

Дорноговь аймагт гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шийдвэрлэлт ямар байна вэ?

Дорноговь аймгийн болон Замын-Үүд сум дахь сум дундын прокурорын газар нь аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулан ажиллаж байна.

Тус аймгийн хэмжээнд 2023 онд 36 мянга гаруй зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 27.5 хувиар өссөн бол гэмт хэрэг 9.0 хувиар өссөн. Нийт бүртгэгдсэн зөрчлөөс үзэхэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, Хүний биед халдах, Танхайрах, Хүүхдийн эрхийг зөрчих, Гаалийн тухай хууль зөрчих, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих зөрчил дийлэнх хувийг нь эзэлж байна.

Харин нийт гэмт хэргийн 51.8 хувь нь Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, тэр дундаа Залилах гэмт хэрэг дангаараа 24.5 хувийг эзэлж байна.

Прокурорын газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

Өнгөрсөн онд аймгийн болон сум дундын прокурорын газраас зарим төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоохоор нийт 12 судалгаа, 8 шалгалт хийж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Тухайлбал, хүүхэд хохирсон болон хүүхэд холбогдсон хэргийн шалтгаан нөхцөл, бага

насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, гэмт хэргийн хохирогч болж болзошгүй эрсдэлтэй хүүхдүүдийн судалгаа зэргийг хийж урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Мөн гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 66 аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдэд прокурорын мэдэгдэл бичиж, холбогдох арга хэмжээг авахуулсан.

Хүүхэд хохирсон гэмт хэргийн судалгааг хийсэн байна. Ямар нөхцөл байдал тогтоогдсон бэ?

Аймгийн хэмжээнд хүүхдийн эсрэг гэмт хэрэг, мөн өсвөр насны хүн холбогдсон гэмт хэрэг жил бүр нэмэгдэж байна. Тиймээс аймгийн прокурорын газраас хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллаж байгаа. Тухайлбал, өнгөрсөн онд энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлыг оновчтой тодорхойлох үүднээс сүүлийн 5 жилд гарсан нийт хэргийг судалсан. Дээрх хугацаанд хүүхэд хохирсон гэмт хэрэг 184 бүртгэгдсэнээс 102 буюу 55 хувь нь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг байгаа нь нэлээд анхаарал татсан. Тиймээс аймгийн прокурорын газраас санаачлан Дорноговь аймгийн хүүхэд хамгааллын байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Аймгийн бүх шатны Засаг дарга, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, шүүгч, прокурор, өмгөөлөгч, цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид болон Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг 200 орчим хүн оролцсон томоохон зөвлөгөөн болсон. Зөвлөгөөнөөр урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлж, хүүхэд хамгааллын байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллагуудаас хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд хийж хэрэгжүүлбэл зохих 12 үүрэг чиглэл бүхий шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал, хүүхэд хамгаалал, иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлтийг сайжруулах зорилгоор аймгийн төв Сайншанд хотыг бүрэн камержуулахаар орон нутгийн өмчийн 1.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тендер зарлагдсан байгаа.

Танай аймгийн хувьд Монгол Улсын хамгийн том, ачаалал ихтэй Замын-Үүд боомттой гэдгээрээ онцлог. Хил, гаалиар нэвтэрч буй иргэд гэмт хэрэг, зөрчилд холбогдох тохиолдол хэр их гардаг вэ, энэ талаар тодруулбал?

Монгол Улсын иргэд улсын хилээр нэвтрүүлэх бараа, эд зүйлийн талаарх хуулийн мэдлэг дутмаг байгаагаас шалтгаалан бусдын ятгалгад автан, амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор гэмт хэрэгт холбогдож, эрүүгийн хариуцлага хүлээх тохиолдол цөөнгүй гардаг.

Тиймээс иргэдэд хууль тогтоомж сурталчлах, яриа таниулга хийх, мөн хилийн бүсээр хүн тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг шалгах зэрэг ажлыг 2023 онд хийсэн. Мөн түүх соёлын үнэт дурсгалт зүйл болох бурхан, судар, шашны

холбогдолтой эд өлгийн зүйлс, архи, тамхи, эмийн хэрэгсэл, амьтан, ургамлын гаралтай түүхий эд зэрэг улсын хилээр гаргахыг хориглодог бараа бүтээгдэхүүний талаар зурагт хуудас бэлтгэж, жолооч, зорчигч нарт тараах, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлэл өгөх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1481